

“Соёлын өвийн үндэсний төв ба музейнүүдийн хамтын ажиллагаа” уулзалтад

Музейн сан хөмрөгийн бүртгэлийн хэл

найруулга, агуулгыг

сайжруулах асуудалд

Д. Цэдмаа

2018.04.06

Өсөхөөс сурсан төрөлх хэл мартаж болшгүй соёл

Б. Ринчин

ОУМЗ-ийн Мэргэжлийн Ёс зүйн Дүрмээс , 2004 он

3.1. Музейн сан хөмрөг анхдагч баримт болох нь

Музейн сан хөмргийн бодлогод сан хөмрөг нь анхдагч баримт гэрч болохын ач холбогдлыг тодорхой тусгана. Бодлогыг зөвхөн орчин цагийн оюун санааны чиг хандлага, музейн хэрэглээгээр хэмжиж болохгүй.

3.9. Мэдлэг туршлагаа хуваалцах

Музейн мэргэжлийн ажилтнууд мэдлэг, туршлагаа хамтран ажиллагч, судлаачид, оюутнуудтай харилцан солилцоно. Ажилтан өөрийг нь сургасан хүмүүсийн ач тусыг ухамсарлаж, тэднийг хүндэлж, бусдын тусын тулд шинэчлэл ба туршлагаа өвлүүлэх үүрэгтэй.

4.2. Үзмэрийн тайлбар танилцуулга

Үзүүлэлт, үзэсгэлэнгийн мэдээлэл нь үндэслэлтэй, шалган магадалсан байх бөгөөд тодорхой бүлэг хэсэгт зориулагдсан бол тэдний эрхэм зүйлин талаар багтаана.

Музей бүх насны, ажил мэргэжлийн хүмүүст зориулагдсан, тэдэнд үйлчилдэг учраас төрөл зүйлээс хамааралгүй өргөн мэдлэг, мэдээлэлийн сан бий болдог. Ялангуяа манай музейнүүд цөөн ажилтантай тул музейн аль ч ажлыг гүйцэтгэх чадвар шаардагддаг.

Музейн сан хөмрөгийн бүртгэл бол үзүүллэг, үзмэрийн холбогдох мэдээлэлийг агуулсан анхдагч эх сурвалж болохын хувьд чухал ач холбогдолтой. Бүртгэлийн үнэн зөв, сонирхолтой мэдээлэл нь сан хөмрөгт хадгалагдаж байгаа цуглуулгын үнэ цэнэ, ач холбогдлыг илрүүлнэ. Харин эд зүйл болгон бүрэн, зөв мэдээлэл, түүхтэй музейд ирдэггүй бөгөөд хэдэн арав, зуун жил өнгөрч, хэрэглэгч эзэн, мэдэх орчноосоо холдсон олон мянган эд зүйлийг судлан тодорхойлох үүрэг музейнхэнд ногддог

Бүртгэлийн дэвтрээс уншиж үзээрэй

Сан хөмрөгийн үе үеийн бүртгэлд эд зүйлийн нэр, нэршил, бүрдэл хэсгүүдийг тоочин бичсэн тул түүхэн газрууд, угсаатан, зан үйл, урлагийн холбогдох агуулга бүхий мэдээлэл арвин их. Иймд ажилтан сан хөмрөгийн бүртгэл хөтлөх, тооллогод оролцох нь холбогдох сэдвээр өргөн мэдлэгтэй болж чадах сайн талтай.

Хэл найруулгыг хэн , хэзээ сайжруулах вэ?

Дарга уу? Би юү ? Одоо юу? Дараа юу ?

Яагаад заавал би гэж, яагаад заавал одоо гэж.

Тасралтгүй бөгөөд хамтаар ажиллах.

Тооллогоос тооллогын хооронд ажиллах

Жишээнээс суралцах” /case study/ нь бодит баримтад тулгуурлан шинжилж, санал боловсруулах судалгааны хэлбэр юм.

Өөрийн практик ажиллагаанаас суралцсанаар:

- Ажилтныг бэлдэж, боловсруулна
- Музейн бусад ажилд бэлдэнэ
- Музейн ажлын арга зүйг хэвшүүлнэ

Бичгийн хэлбэр зөв, агуулга ойлгомжтой байх

Ширэн толгойтой, гүүшн
нуухтай, бушгаар тавтай,
ясан халбагайттай, нэрнү
ногоон гүүшн.

Хөх саарал өнгөтэй,
их биеийн эргэн тойронд
цэцэг, амьтны дүрс
сийлсэн, хар саарал
хиймэл гүүшн тол-
гойттой, гүүшн хөөрөг

-Улаан хирэн хошоотой
ухал тэвчлэн торгон даа
-Ясан халбагайттай,
мөнхтэй.

6

Ширэн ширэн нь 5м голлоо
махаин ширэн, буш 1м
хошиой махаин ширэн,
гүрэн гүүшнтэй, гүүшн
их өнгөтэй. Малгай саарал
начигдори, хари, баг, нэрл
ашиг, тогз биеийн хөшөө
хийсэн. Шир, оюу, сүвд, ширэн
хийлэвч. Нийлн 01-57,5 м,
дун 57,5 м, дун 1,3 м 29

Бичиг ширэн багд ала
барин баруун ширэн нэгдэх
замтай (дөрвөн үндсэн, өнгөтэй)

Найруулга тааруу, ойлгомжгүй дүрслэл ба үг, үсгийн алдаа

- - ширээний хацартаа- хацартай, дарцаараа-дардсаараа, уужний- уужны, танкийн сад- саад
- - 1959.5.4. Ухна сийлбэр. ... хуцны бүтэн биеийг сийлбэрлэсэн /Нэр нь ухна байсанаа, бичлэгт хуц__ болсон , аль нь зөв бэ, мөн ооч ? сахал ...
- - 1959.5.3. Хуц сийлбэр. ...Хонины сүүл ар талдаа үзүүр нь сөхөгдсөн /ар тал гэж илүү, үзүүр нь сөхөгдсөн гэж байгаа , сүүлний ар гэж? /
- -1958.1.2.Тариа цайруулах самбар чулуу- Паралепрам дүрстэй- гэж бичсэн нь гаргагдахгүй, ойлгомжгүй
- -98х-9-2. Улаан сахиусны шуумал дүр. Улаан хүрэн будагтай, шургуулган тагтай жижиг баг.

Тэмдэглэх нь:

- Уран зургийн зураачийг бичээгүй их байна, орон нутагт зураачийг таньж олох боломж бий.
- Хөөрөг- толгойгүй гэж бичээгүй их байна, толгойгүй гэж тааварлах уу. Ахуй хэрэглээний эд зүйлд илүү анхаарах.
- Уран зураг, монгол зураг, бурханы зургийн ард юу бичигдсэн, зураас тэмдгийг тэмдэглээгүй
- Зургийн жаазны тухай мэдээлэл алга

Баримт, мэдээлэл үндэслэх

- 1945.01. Тамга- хуучин хувийн дугаар нь 1931 байсаныг, 1980 оны тооллогын бүртгэлд 1945 он гэсэн тул 1945.01 болгосон. 1931 нь 4 орон оронтой, тоон бүтцээр шинэ дугаартай ижил, ямар нэг үндэслэлтэй бичигдсэн байсан, хуучин цаг үед хамаарах үзмэрээ он цагаар хойшлуулсан.
- - Д-213- 232д. 33 улаан шүр 18 хувийн дугаарт бичигдсэн, өр1см, у-1,2, нүхтэй эсвэл шигтгээ гэж бичээгүй, ингэж ижил олон зүйлийг тус бүрт нь дугаар өгөх нь цогц зүйлийг салгасан.

Оновчтой, ойлгомжтой, энгийн үг сонгох

- 1945.01. Тамга Квадрат хэлбэрийн дөрвөлжин суурьтай – ижил утга давтсан.
- 1958.02. Модон бар- тэгш өнцөгтэй - өнцөг нь ялгах шинж биш, дүрсийн нийтлэг хэсэг.
- 1957.3.1. Цөгц- хүн чулуу хээгээр чимсэн, -/ хүн чулуу – хээ мөн үү?, хүн чулуу дүрсэлсэн гэх, үнэхээр хүн чулуу дүрс үү/.
- 62.04.5. Хүрэл чимэглэл. Бамбаруушны толгой шиг хэлбэртэй голдоо нүхтэй /Их бие үү, нүхний дүрс үү, /

Судлах, тодруулах ба ажилтнууд хамтран ажиллах, тооллогод бэлдэх

- Бүртгэлийн дэвтрийн 21 –р баганад тайлбар гэдэгт огт тэмдэглэл бичихгүй нийтлэг байна , зүй нь цаашид судлах, тодруулах, зассан бол ямар үндэслэлээр өөрчилсөнийг тэмдэглэх тухай зөвлөмж өгсөн. Хоёр тооллогын хооронд энэ мэдээллийн дагуу судлах, тодруулах ажил хийвэл тустай .
- 1958.0.8. Бүртгэлд: Ган сэлэм – нэг талдаа P D. LUNESCHLOSS SOLINGEN англи үсэгтэй, бариулын хажууд саран дээр суусан хүүхдийн дүрстэй. Энэ нэрийг тодруулж үзэхэд : англи үсэг биш, харваас герман нэр. Герман улсын SOLINGEN –Золиген хотод байрладаг, P D. LUNESCHLOSS-үйлдвэрийг 1810 онд байгуулсан эзний нэр бичигджээ. Эртний цэргийн зэвсгийг дуурайлган хийдэг үйлдвэр бөгөөд SOLINGEN хутгаараа алдартай.
- 1959.0.2. Зоос. Зоосон дээрх тэмдгийг дүрслэн зурсан нь бичсэнээ бататгах сайн талтай.

- 1960.2.1. “Чи” маажин багвар гэж бичжээ. Үүнийг тодруулж үзэхэд: Чий маажин – эд зүйлд гялалзсан өнгө оруулдаг нэгэн зүйл будаг. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. МУШУА 2008 он .
- Энэ багварын материал гэдэгт “хуванцар” гэжээ. Маажиндсан багвар голдуу хятад хийцийн улаан өнгөтэй, сүрлээр сүлжсэн, эсвэл шавар байдаг, дээр үед хэрэглэгдэж байсан. Хуванцар бол химийн бүтээгдэхүүн, сүүл үед сав суулга хийх болсон. Мөн 1960.2.2 Чи маажин ваар- мөн “хуванцар” – гэжээ.
- 70.278. Бага даргын шоргоолж- цэргийн дүрэмт хувцасны мөрдсийг хэлжээ
- Дэс 110-138. Бурхан Бүгд нэрлэж бичээгүй бөгөөд барьц, суудал зэргийг

Дүрслэх урлагийн төрлүүд, нэр, арга технологийн талаар мэдлэг дээшлүүлэх

- Уран зургийг “материал”д бичсэн “тосон будаг”гэдгээс олж төрлийг нь мэдэж болно. Урлаг уран сайхны гэж ерөнхий нэрлэсэн. Уран зураг, зураасан зураг, уран баримал, ингэмэл гэх мэт

Судлах, тодруулах ба ажилтнууд хамтран ажиллах, тооллогод бэлдэх

- Бүртгэлийн дэвтрийн 21 –р баганад тайлбар гэдэгт огт тэмдэглэл бичихгүй нийтлэг байна , зүй нь цаашид судлах, тодруулах, зассан бол ямар үндэслэлээр өөрчилсөнийг тэмдэглэх тухай зөвлөмж өгсөн. Хоёр тооллогын хооронд энэ мэдээллийн дагуу судлах, тодруулах ажил хийвэл тустай .
- 1958.0.8. Бүртгэлд: Ган сэлэм – нэг талдаа P D. LUNESCHLOSS SOLINGEN англи үсэгтэй, бариулын хажууд саран дээр суусан хүүхдийн дүрстэй. Энэ нэрийг тодруулж үзэхэд : англи үсэг биш, харваас герман нэр. Герман улсын SOLINGEN –Золиген хотод байрладаг, P D. LUNESCHLOSS-үйлдвэрийг 1810 онд байгуулсан эзний нэр бичигджээ. Эртний цэргийн зэвсгийг дуурайлган хийдэг үйлдвэр бөгөөд SOLINGEN хутгаараа алдартай.
- 1959.0.2. Зоос. Зоосон дээрх тэмдгийг дүрслэн зурсан нь бичсэнээ бататгах сайн талтай.

Цаашид

- Ажилтан байгууллагадаа боловсрох, хөгжихийг эрхэмлэх
- Музей өөрсдийн аргачлал, лавлах, гарын авлагатай болох
- Бүртгэлийн бичилт, хөтлөлтөд тооллогын хооронд нягтлах
- Тооллогод бэлтгэх

Анхаарал тавьсанд баярлалаа

